

БНХАУ АЗИЙН ХУДАЛДААНЫ ХЭВ МАЯГ БА ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ

Улаанбаатар, Монгол Улс (2003.04.28) –БНХАУ тус тивд худалдаанд хүч түрэн гарч ирсэн нь Азийн хөгжиж буй орнуудын худалдааны хэв маяг ба өсөлтөд том нөлөө үзүүлээ гэж Манилд төвтэй АХБ-аас өнөөдөр гаргасан “Азийн Хөгжлийн Төлөв Байдал 2003” -д дурьджээ.

АХУТБ хэмээх Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн чиг хандлагыг шинжилж урьдчилсан таамаг дэвшүүлдэг энэ товхимолд Азийн хөгжиж буй орнуудын дэлхийн бусад оронтой хийсэн худалдааны нийт хэмжээ 2002 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд эрчимтэй өссөн гэж мэдээлжээ. Энд иш татсан зарим нэг худалдааны тоо баримтыг дурдвал, тус бүс нутгийн нийт экспортын хэмжээ 2002 оны 1 дүгээр сард 50.6 тэрбум ам доллар байсан бол 9 дүгээр сард 31.3%-иар өсч 66.4 тэрбум ам долларт хүрч Ази тив цэвэр экспортлогч болж чадсан байна.

Хөгжиж буй Азийн нийт импортийн хэмжээ 2001 оны 9 дүгээр сард 46 тэрбум байсантай харьцуулахад өсөлтийн хурдац багасч 1.4 тэрбум ам доллараар буюу 3%-иар өсчээ.

БНХАУ, Хятадын Хонконгийн 1990-2001 онуудын хооронд дэлхийн бусад хэсэгтэй хийсэн худалдаа гурваас илүү дахин өсчээ. Мөн хугацааны туршид Зүүн Өмнөд Азийн дэлхийн бусад орнуудтай хийсэн худалдаа бараг хоёр дахин өссөн байна. БНСУ, Монголын дэлхийн бусад улстай хийсэн худалдаа мөн адил хэмжээгээр өсчээ.

БНХАУ ба Хонконг; БНСУ ба Монгол; Зүүн Өмнөд Ази тус бүрийн дэлхийн бусад орнуудтай хийсэн худалдааны тэнцэл илүүдэлтэй хэвээр байна.

Ази, номхон далайн бүс дотроо Зүүн Өмнөд Ази, БНСУ ба Монгол улс нь хоёулаа БНХАУ ба Хонконг руу тэдгээрээс импортлохоосоо илүү хэмжээгээр экспортолжээ.

1990-2001 оны хооронд БНСУ ба Монгол, Зүүн Өмнөд Азийн хооронд хийсэн худалдаа бараг гурав дахин өсч экспорт, импорт нь бараг тэнцсэн хэвээр байна. БНХАУ ба Хонконг руу Зүүн Өмнөд Азийн хийсэн экспортын хэмжээ түүний бусад улстай хийсэн худалдаанаас илүү хурдан өсчээ.

Төрөл бүрийн боловсруулсан бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгч, экспортлогч болох БНХАУ тус бүс нутгийн ижил төрлийн бүтээгдэхүүн экспортлогч бусад орнуудыг шахан зайлуулна гэсэн болгоомжлол байгаа тухай АХУТБ-д дурджээ. Гэхдээ бусад улсууд ч БНХАУ ба Хонконгийн эдийн засгийн хөгжил хөдөлгөөнөөс ашиг тус олж авсныг тоо баримт харуулж байна. Учир нь тэдгээрийн худалдааны хэмжээ түргэн нэмэгдэж тэдгээр улсууд нийт дүнгээр нь авч үзвэл БНХАУ ба Хонконг руу цэвэр экспортлогч болж байгаа юм.

Гадны орнуудаар бараа, үйлчилгээгээр гэрээлж хийлгэх болсон ба үйлдвэрлэлийн дамжлага улам боловсронгуй болсон зэрэг нь Азийн орнуудын хоорондын болон тэдгээрийн дэлхийн бусад хэсэгтэй хийх худалдааг түргэн өсөхөд жинтэй хувь нэмэр оруулжээ.
